

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ**

2018.12.31

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Ажил үйлчилгээ	Биелэлт
Нэг. Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, гүйцэтгэлийн удирдлага			
1.	1.1 Салбарын хэмжээнд төрийн албаны шинэтгэл, төрийн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	1.1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төв, орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, ШШГЕГ-ын 2017 оны үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэж, 2018 оны зорилтыг тодорхойлох;	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/293 дугаар тушаалаар батлагдсан тус ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц орон тооны хүрээнд зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг батлан ажиллаж байна.</p> <p>ШШГЕГ-ын даргын 2018.01.22-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төв, орон нутгийн удирдах ажилтнуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 2018 оны 01 дүгээр сарын 29-нөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус сургалт, зөвлөгөөнд нийт 84 удирдах албан тушаалтан хамрагдсан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга төв, орон нутгийн 47 анги, байгууллагын дарга нартай 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулав.</p>
		1.1.2. Төрийн албаны болон бусад хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүргийн биелэлтийг зохион байгуулах;	<p>Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, МУ-ын Засгийн газрын 258 дугаар тогтоолыг үндэслэн ШШГЕГ болон харьяа хорих анги, байгууллагад ажиллаж буй алба хаагчдын ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах зорилгоор ажлын байрны шинжилгээ хийх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг ШШГЕГ-ын 2018.10.10-ны өдрийн А/178 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй нийт 370 ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийсэн.</p> <p>МУ-ын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгосонтой холбогдуулан ШШГЕГ-ын даргын “Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх тухай” 2018.02.08-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаас тус байгууллагын удирдах ажилтнуудад өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ШШГЕГ-ын даргын 2018.04.03-ны өдрийн А/78 дугаар тушаалын дагуу ШШГЕГ-ын харьяа орон нутаг дахь хорих анги, байгууллагуудад “Сахилга, хариуцлагын зөвлөгөөн”-ийг 2018 оны 04 дүгээр сарын 09-13-ны өдрүүдэд, ШШГЕГ-ын алба, газар, нийслэлийн хүрээний хорих анги, байгууллагуудын ахлах мэргэжилтнүүд болон түүнээс дээш албан тушаалд ажиллаж буй 173 удирдах ажилтнуудыг оролцуулсан “Сахилга хариуцлагын нэгдсэн зөвлөгөөн”-ийг 2018 оны 04</p>

			<p>дүгээр сарын 19-ний өдөр тус тус зохион байгуулан ШШГБ-ын удирдлагууд нийт бие бүрэлдэхүүнд сахилга, хариуцлага, дэг журам, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгсөн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд алба, газар, хорих анги, байгууллага бүр “Ажлын хэсэг” байгуулан албаны байр, өрөө тасалгаанд согтууруулах ундаа хэрэглэх, хадгалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх, сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах зорилгоор алба хаагчдын ажлын байрны сахилга бат, зохион байгуулалт, баримт бичгийн эмх цэгц, хадгалалт хамгаалалт, хориотой эд зүйл байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгалаа.</p> <p>Үзлэгээр ямар нэгэн согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис гараагүй бөгөөд цаашид бичиг баримтын хадгалалт, хамгаалалт, эмх цэгцийг хангаж, ажлын байрны ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, албан өрөөндөө, үүрэг гүйцэтгэх үедээ, үүрэг гүйцэтгэхээр ирэхдээ архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх талаар үүрэг өгч, алба хаагчаар гарын үсэг зуруулан баталгаажууллаа.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/148 дугаар тушаалаар ШШГЕГ-ын даргын 2013 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.4-д “алба хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглоно” гэж нэмэлт өөрчлөлт оруулав.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан Төрийн албаны хууль/шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ШШГЕГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гарган 2018.12.03-ны өдрийн 01/4902 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлэв. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, төрийн жинхэнэ алба хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх арга хэмжээг 2018 оны 11 дүгээр сарын 15-23-ны өдрүүдэд байгууллагын хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж нийт 56 анги, байгууллагын 2860</p>
--	--	--	---

		<p>алба хаагчийг хамруулж, дүнг нэгтгэн 2018.11.27-ны өдрийн 01/4813 дугаар албан бичгээр ХЗДХЯ-нд, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүллээ.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн үүрэг, даалгаврын биелэлтийг 2018.05.25-ны 01/01, 2018.05.25-ны 01/02, 2018.06.05-ны 01/2210, 2018.06.28-ны 01/2605, 2018.08.31-ний 01/3400, 2018.08.28-ны 2а/3345 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.</p>	
	<p>1.1.3. Төрийн албаны болон бусад хууль тогтоомж, төрийн албаны стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар харьяа нэгжүүдэд арга зүйн зөвлөгөө өгөх, үр дүнг тооцох;</p>	<p>Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг аргачиллаар хангах зорилгоор худалдан борлуулах, эрэн сурвалжлах ажиллагаа, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх, бие даан худалдан борлуулах, шинжээч ажиллагаанд оролцуулах, төлбөрийн хуримтлалыг бууруулах, зардлын зарцуулалтад хяналт тавих чиглэлээр үүрэг, даалгавар, зөвлөмжийг харьяа нэгжүүдэд хүргүүлж, аргачиллаар хангасан.</p> <p>ШШГЕГ-ын даргын 2017.03.10-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар баталсан “ШШГБ-ын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг анги, байгууллагад хүргүүлэн, биелэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэхэд Монгол улсын хууль тогтоомж, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг биелүүлж, эрхээ хэрэгжүүлэх явцад баримтлах хуульд нийцүүлэн гаргасан заавар, журам, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэд, байгууллага, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл болон хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг шалган дүнг “Ёс зүйн салбар хороо”-ны хуралдаанаар хэлэлцэн, зөрчил гаргасан эсэх, тухайн ажилтан гэм буруутай эсэх, түүнд хариуцлага хүлээлгэх эсэх талаар гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргаж, тухайн нэгжийн даргын зөвлөлийн хуралдаанд санал уламжлан шийдвэрлүүлж хэвшсэн.</p> <p>Түүнчлэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг алба хаагчдад чанд мөрдүүлэх, сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр хичээл сургалтыг зохион байгуулан, албан үүргээ гүйцэтгэхдээ албаны нэр төрийг өндөрт өргөж, аливаа зөрчил гаргахгүй ажиллахыг үүрэг болгосны зэрэгцээ дотооддоо “Ёс зүйн талон”, “Сахилгын хуудас”, “Сахилгын талон” зэргийг санаачлан хэрэгжүүлж хэвшсэн.</p> <p>ШШГЕГ-ын удирдлагууд тус байгууллагын бүх шатны удирдах ажилтан, нийт бие бүрэлдэхүүнд хандаж сахилга, хариуцлага, дэг журам, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлээр ШШГЕГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/78 дугаар тушаалын дагуу ШШГЕГ-ын харьяа төв, орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар,</p>	

			<p>хэлтэс, хорих анги, салбар нэгжүүдэд “Сахилга, хариуцлагын зөвлөгөөн”-ийг 2018 оны 04 дүгээр сарын 09-13-ны өдрүүдэд, ШШГЕГ-ын алба, газар, Нийслэлийн хүрээний Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, салбар нэгжийн ахлах мэргэжилтнүүд болон түүнээс дээш албан тушаалд ажиллаж буй 173 удирдах ажилтнуудыг оролцуулсан “Сахилга хариуцлагын нэгдсэн зөвлөгөөн”-ийг 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр тус тус зохион байгуулж үүрэг даалгавар өгч ажилласан.</p>
Хоёр. Төрийн албаны хүний нөөцийн хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт			
2	<p>2.1.Байгууллагыг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр хангах</p>	<p>2.1.1. Байгууллагын 2018 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, алба хаагчдыг давтан, мэргэшүүлэн сургах, хэрэгцээг тодорхойлох;</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар “2018 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зохион байгуулах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж, дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <p>Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс санаачлан Хуульзүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд 15 байгууллагын 70 гаруй багш, судлаачид, удирдах болон практик ажилтнууд оролцов.</p> <p>Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулиас зохион байгуулж буй “Ахлагч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд 405 дугаар хаалттай хорих ангийн хамгаалалтын ажилтан, дэд ахлагч Б.Мөнхбилэгтэйн материалыг тус их сургуулийн Ахлагчийн сургуульд хүргүүлж илтгэлийг хэлэлцүүлсэн.</p> <p>ХСИС-иас зохион байгуулсан “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд Аюулгүй байдлын хэлтсийн дарга, хурандаа П.Хосбаяр, тус хэлтсийн Ажиллагааны тасгийн дарга, ахмад Б.Энхтөр, ахлах мэргэжилтэн хошууч, С.Золжаргал нар оролцлоо.</p> <p>Хууль сахиулахын их сургуулийн хурлын танхимд зохион байгуулагдсан “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт”-ийн талаарх хэлэлцүүлгийг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, ХСИС хамтран зохион байгуулсан.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017.12.05-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар “2018 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зохион</p>

			<p>байгуулах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж, дараах сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/50 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийгмийн ажилтны мэргэшүүлэх сургалтад 53, Сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх сургалтад 26, нийт 79; - Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албатай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сувилагчдыг мэргэшүүлэх, кредит олгох сургалтад 75; - 2018 оны 05 дугаар сарын 15-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан санхүүгийн алба хаагчдын бүсчилсэн сургалтад 190; - Хорих байгууллагын хуяглан хүргэлтийн ажилтны мэргэшүүлэх сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Хууль сахиулахын их сургууль, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан сургалтад 35; - 2018 оны 05 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Хорих ангийн харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх сургалт”-д 24; - 2018 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Иргэний, Захиргааны, Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон эрэн сурвалжлах ажиллагааны чиглэлээрх эрх зүйн зохицуулалтыг нэр мөр ойлголтоор хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтад төв, орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгийн 52 ахлах шийдвэр гүйцэтгэгч; - 2018 оны 10 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд хорих анги, байгууллагын инженер, техникч, холбоочин, дүрс бичлэгийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад 78; - 2018 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд хорих анги, байгууллагын сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад 53; - 2018 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарыг мэргэшүүлэх сургалтад 53; - 2018 оны 11 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд хорих анги, байгууллагын эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад 80;
--	--	--	--

			<p>- 2018.12 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд хорих анги, байгууллагын цагдан хорих байрны дарга, ахлах төлөөлөгч нарыг мэргэшүүлэх сургалтад 48 алба хаагч тус тус хамрагдлаа.</p> <p>Алба хаагчдыг чадавхижуулах ажлын хүрээнд ХСИС-ийн Ахлагчийн сургуультай хамтран ШШГБ-д энгийнээр томилогдон ажиллаж буй 115 шийдвэр гүйцэтгэгчид “Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох”, ШШГБ-д цэргийн орон тоонд энгийнээр томилогдон ажиллаж буй 35 алба хаагчид “Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох”, АТГ-ын Олон нийтийн төвөөс удирдах албан тушаалтан, хууль, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа хариуцсан 71 алба хаагчид тус тус сургалт зохион байгууллаа.</p> <p>Мөн хорих анги, байгууллагуудад шинээр томилогдон ажиллаж байгаа 54 алба хаагчдад цэргийн хэргийн мэдлэг олгох давтан сургалтыг 2018 оны 09 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулж, “Гэрчилгээ” олгосон.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018.01.15-ны өдрийн А/10 дугаар “Мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулах тухай” тушаалыг баталж, нийт бие бүрэлдэхүүнд 12 удаа цаг үеийн шинжтэй мэдээ мэдээлэл хийж, үүрэг даалгавар өгч ажилласан.</p> <p>Мөн Монголын бүтээмжийн төвийн эксперт багш Б.Ариунзаяа “Алба хаагчдын санал санаачилгыг нэмэгдүүлэх нь”, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн П.Оюунчимэг “Хорих байгууллага дахь хүний эрх”, “Хөх Монголын зөн” ТББ-ын тэргүүн Ш.Бэрцэцэг “Сайхан амьдралын үндэс”, Архивын ерөнхий газрын мэргэжилтэн А.Дэлгэрцэцэг “Архив албан хэрэг хөтлөлт”, Улаанбаатар их сургуулийн багш Б.Мөнгөнтуул “Цагийн менежмент”, ХЯЭА-ны Шуурхай удирдлагын төвийн ахлах мэргэжилтэн, х/ч С. Баясгалан “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”, “Монгол генерал төв”-ийн гүйцэтгэх захирал, хошууч генерал З.Болдбаатар “Тусгаар тогтнол бүрэн эрхт байдалд цэргийн алба хаагчдын үүрэг оролцоо”, Нийслэлийн онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Чинбат “Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх нь”, Хууль сахиулах их сургуулийн эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, ахмад О.Отгонтуяа “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн үзэл баримтлал, ЦЕГ-ын хяналт шалгалт, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх “Төрийн тусгай алба хаагчийн харилцааны ур чадварын манлайлал”,</p>
--	--	--	---

			<p>“Удирдагчдын уурхай” ТББ-ын тэргүүн, зөвлөгч багш, сэтгэл судлаач Ч.Түдэвсүрэн “Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх”, Хүний хөгжлийн оюуны чадвар төв”-ийн захирал, үндэсний уран илтгэгч Г.Мөнгөн “Бүтээмж нэмэгдүүлэх ажилтны хувийн хөгжил”, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, Д.Баатарсайхан “Төрийн албаны тухай хууль”-ийн өөрчлөлт шинэчлэл, ЦЕГ-ын ХШУДАХ-ийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх “Эрсдлийн удирдлага”, Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн зохицуулагч, дэслэгч Э.Ариунболд “Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрэм”, ХСИС-ийн зөвлөх багш, доктор, профессор О.Цэцэгмаа “Байгууллагын хөгжлийн бодлого, суралцагч байгууллага”, ХСИС-ийн доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Н.Мөнхзул Үндсэн хуулийн агуулга, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, ХСИС-ийн ахлах багш, цагдаагийн ахлах дэслэгч Д.Ариужин, Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрын хэлтсийн дарга, Б.Билэгдэмбэрэл нар “Төрийн байгууллагуудын дижитал шилжилт” сэдвээр, “Мэдээллийн аюулгүй байдал”, Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Д.Дэлгэрзаяа Үндсэн хуулийн агуулга, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн н.Нандинцэцэг “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим”, “Нэгдмэл дэлхий” ТББ-ын тэргүүн Д.Гончигдорж “Байгууллагын харилцаа, ёс зүй”, ШУТИС-ийн ахлах багш н.Ариунтуяа “Стресс түүнийг даван туулах аргууд”, “Алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэл” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.</p> <p>"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2018-2019 онд зохион байгуулах албаны сургалтын хөтөлбөр"-ийн төслийг ШШГЕГ-ын даргын зөвлөлийн 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2018.09.27-ны өдрийн А/169 дүгээр тушаалаар батлуулан сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Оросын Холбооны Улсын их, дээд сургууль болон Удирдлагын академид 18, Бүгд Найрамдах Солонгос улсад 2 нийт 20 алба хаагч тус тус суралцаж байна. Үүнд: ОХУ-ын Дотоод хэргийн яамны харьяа Омск хотын академид 4, ОХУ-ын Дотоод хэргийн яамны Москва хотын удирдлагын академид 3, докторантурт 2, ОХУ-ын Дотоод хэргийн яамны Екатеринбург хотын их сургуульд 7, ОХУ-ын Волгоград хотын хэлний бэлтгэлд 2 алба хаагч тус тус суралцаж байна.</p>
--	--	--	---

			<p>Хууль сахиулахын их сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилд бакалаврын сургалтад 174, эчнээгийн 3 жилийн ангид 78, эчнээгийн 5 жилийн ангид 57, магистрын сургалтад 17, удирдлагын сургалтад 3, докторын сургалтад 7, дотоодын бусад их, дээд сургуулийн бакалаврын сургалтад 9, магистрантурт 16, докторантурт 3 алба хаагч тус тус суралцаж байна.</p> <p>Мөн Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын академийн “Хууль сахиулах захиргааны удирдлага” 1.5 жилийн хөтөлбөрийн гарагийн сургалтад 7, “Стратеги-тактик удирдлага” 1.5 жилийн хөтөлбөрийн улирлын сургалтад 2 нийт 9 алба хаагч хамрагдаж байна.</p> <p>Хууль сахиулахын их сургуулиас 2018-2019 оны хичээлийн жилд “Гэмт явдал судлал-эрх зүй” чиглэлийн магистрын сургалтад 16, “Боловсрол судлал”-ын магистрт 1 алба хаагч суралцаж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, ахлагч бүрэлдэхүүний нөөц бүрдүүлэх зорилгоор харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтыг 2018 онд 3 удаа зохион байгуулж байна. 1 дүгээр ээлжийн сургалтнаас 90, 2 дугаар ээлжийн сургалтнаас 75 иргэн тус тус тэнцэж хорих анги, байгууллагад томилогдон ажиллаж байна.</p>
		<p>2.1.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;</p>	<p>Алба хаагчдын ая тухтай, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, амьдралын түвшин, ахуй нөхцөлийг дээшлүүлэх, амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор ШШГЕГ-ын даргын тушаалаар “ШШГБ-ын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг батлан 2016-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, чиглэл гарган ажиллаж байна.</p> <p>Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2018 онд 104 алба хаагч, 94 ахмад настанд 191 сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмж тус тус олголоо.</p> <p>2018 онд 401, 403, 405, 407, 409, 421, 423, 429 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиуд зэрэг олон байгууллагууд алба хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдах тавилга, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, 409, 421, 427, 441, Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих анги, Баривчлах төв зэрэг ихэнх байгууллагууд албан контор болон алба хаагчдын ажлын өрөөнд урсгал засвар хийж, мөн алба хаагчдын сэтгэл</p>

			<p>зүйн үйлчилгээ бүхий алжаал тайлах өрөөг тохижуулсан байна. Тухайлбал;</p> <p>-409 дүгээр хаалттай хорих анги үйлдвэрийн зориулалтын 189.2 кв талбайтай байрыг хурлын танхим болгон засварлаж, шалыг паркетлан, хурлын индэр, ширээ зэргийг хийж тохижуулан, проектор байршуулж, дүрс дууны холболтыг бүрэн хийж ашиглаж хэвшээд байна.</p> <p>-Мөн цэргийн албан хаагчдын бэлтгэл сургуулийн талбайд 7023.0 төгрөгийн зардлаар өргөтгөл хийж хуш, хус, нарс, улиас, бургас зэрэг 5 төрлийн мод тарьж, ногоон орчин бий болгохын зэрэгцээ автомашины зам, 48 автомашины багтаамжтай тохилог зогсоолыг тус тус шинээр байгуулжээ.</p> <p>-405, 421, 429 дүгээр хорих анги зэрэг анги, байгууллагууд төрийн албаны тогтвортой байдлыг хангах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх ажлын хүрээнд 2018 онд шинээр томилогдсон болон шилжиж ирсэн алба хаагчийг сурган дадлагажуулах багшийг ангийн даргын тушаалаар томилон, алба хаагчдынхаа ар гэрээр очин амьдрал ахуйтай танилцан, санал бодлоо солилцох зэргээр тогтвор суурьшилтай, идэвх санаачлагатай ажиллах урам зориг бий болгоход чиглэгдсэн олон ажлуудыг зохион байгуулан ажиллажээ.</p> <p>-409, 429 дүгээр хаалттай хорих анги, 421 дүгээр нээлттэй хорих ангиуд шинээр томилогдсон алба хаагчдад ангийн Сэтгэл зүйч “Сэтгэл зүйн тодорхойлолт” гаргаж өгдөг, мөн зөрчил, дутагдал гаргасан алба хаагчийн сэтгэл санааны байдлыг судлан харилцан ярилцаж, сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зорилгоор “Холбон зуучлах хуудас”-аар Сэтгэл зүйчид хандан дүгнэлт гаргуулдаг шинэлэг арга барилыг нэвтрүүлсэн байна.</p> <p>-439 дүгээр хаалттай хорих анги алба хаагчдын дунд “Цэргийн жавхаа-4” нэгдсэн аяныг зарлан үндсэн ажлын үзүүлэлт, цэрэгжилт, жагсаалч байдал, сахилга хариуцлага, ёс зүй, спортын тэмцээн уралдаан, олон нийтийн ажлын оролцоо зэрэг төрлөөр дүгнэн хамт олноо тэргүүлсэн нэр бүхий 23 алба хаагчийг сарын үндсэн цалингийн 15-25 хувиар шагнаж урамшуулсан.</p> <p>- 405 дугаар хаалттай хорих ангийн алба хаагчдын гэр бүлийн гишүүд болон хорих ял эдэлж буй хоригдлуудын гэр бүлийнхний дунд байгууллагын үйл ажиллагааг танилцуулж сурталчлах “Нээлттэй өдөр”-ийг 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдөр оройн “Туяат тоо” арга хэмжээг зохион байгуулж алба хаагчдын гэр бүлд хүндэтгэл үзүүлжээ.</p>
--	--	--	--

			<p>2. Алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 2018 онд дараах бүтээн байгуулалтын ажлыг хийсэн. Үүнд:</p> <p>-Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГХ-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид алба хаагчдын 28 айлын 4 давхар, орон сууц;</p> <p>-Нийслэлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт 84 айлын 12 давхар орон сууц;</p> <p>-439 дүгээр хаалттай, хорих ангид 4 айлын, 1 давхар 2 орон сууцыг тус тус барьж, ашиглалтад оруулсан.</p> <p>- Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор халаалт, цэвэр, бохир усны нэгдсэн төвийн шугамд холбогдсон, автомашины гражтай 4 айлын амины орон сууцыг барьж ашиглалтанд оруулсан.</p> <p>- Мөн тус ангид 17 дахь жилдээ тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа хамгаалалтын ажилтан, ахлах ахлагч Ч.Жаргалсайханд хамт олны идэвх санаачилгаар 7х8 харьцаатай өвлийн сууц барьж өгч, амьдрах ая тухтай нөхцөлийг бүрдүүлж ажилласан.</p> <p>- Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын Дэнж багт дулаан, цэвэр, бохир усан хангамжийн төвлөрсөн шугамд холбогдсон 19м х8,5м харьцаатай 4 айлын орон сууцыг барьж дуусган алба хаагч нарт хүлээлгэн өгсөн.</p> <p>- Мөн Баян Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт 20 айлын 0,7 га газар авч алба хаагчдад хүлээлгэн өгч нэг загварын байшин, хашаа барихад хүн хүчний туслалцаа үзүүлсэн.</p> <p>- Булган аймаг дахь ШШГГ нь 29 алба хаагчийг зуслангийн газартай болгосон зэрэг олон сайхан бүтээлч ажлыг хийсэн байна.</p> <p>3. 2018 онд харьяа хорих анги, байгууллагын албан контор, алба хаагчийн ажлын байрны ахуй нөхцөлийг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p>
--	--	--	--

			<p>- 421 дүгээр нээлттэй хорих ангийн алба хаагчдын цайны газар;</p> <p>- Өвөрхангай аймаг дахь ШШГГ-т “Нэг цонхны үйлчилгээ, цагдан хорих байр бүхий албан контор;</p> <p>- Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн Цагдан хорих төвийн “А, В, С” корпус “Албан контор”-ын цэвэр болон бохир усны хуучин шугамыг шинэчлэн солих засварын ажил;</p> <p>Мөн тус анги руу явдаг 600 метр шороон замыг шороон суурьтай, бетононзам болгон шинэчлэн барьж дуусгасан.</p> <p>-Хэнтий аймаг дахь ШШГГ-419 дүгээр нээлттэй хорих ангийн “Нэг цонхны үйлчилгээ бүхий шалган нэвтрүүлэх байр”;</p> <p>-Баривчлах төвд “Нэг цонхны үйлчилгээ бүхий шалган нэвтрүүлэх байр”;</p> <p>-Говьсүмбэр аймаг дахь ШШГГ-425 дугаар нээлттэй хорих анги болон Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт (9мх6м хэмжээтэй, 54м² талбай бүхий 1 давхар) “Шалган нэвтрүүлэх байр”-ны барилгыг тус тус шинээр барьсан.</p> <p>-Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги: “Нэг цонхны үйлчилгээ төв”-ийн өргөтгөлийн барилга зэргийг нэрлэж болно.</p> <p>4. 2018 онд ШШГБ-ын нийт 2912 алба хаагчийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулан, алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, нөхөн төлбөрийг нэмэгдүүлэх зорилгоор 35.5 сая төгрөгийн даатгалын нэмэлт гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>5. Хорих анги, байгууллагууд нь жил бүрийн цагаан сарын шинийн нэгэн, Монголын ахмадын баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ахмад ажилтнуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх, тэдний ар гэрийн гачигдал, эмчилгээний зардалд нийт 34.489.000 төгрөгийн туслалцаа үзүүлсэн байна.</p> <p>6. Төрийн жинхэнэ алба хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж А, В дүгнэгдсэн алба хаагчдыг үндсэн цалингийн 40-80 хувиар шагнаж урамшуулсан.</p> <p>7. Алба хаагчдын амьдралын нөхцөл байдлыг харгалзан дэмжлэг үзүүлэх зорилгоор 70 алба хаагчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүллээ.</p>
--	--	--	--

			<p>8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 75 алба хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан бөгөөд бие бялдарыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор спорт зааланд хуваарийн дагуу спортоор хичээллүүлж байна.</p>
<p>2.2. Алба хаагчдын сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар</p>		<p>2.1.3. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг байгуулах, дүгнэх асуудлаар байгууллагын хэмжээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, удирдлагаар хангах;</p>	<p>ШШГЕГ-ын даргын 2018.01.22-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төв, орон нутгийн удирдах ажилтнуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 2018 оны 01 дүгээр сарын 29-нөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус сургалт, зөвлөгөөнд нийт 84 удирдах албан тушаалтан хамрагдсан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга төв, орон нутгийн 47 анги, байгууллагын дарга нартай 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулав.</p>
		<p>2.2.1. Алба хаагчдын гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд дүгнэлт хийж, судлан харьяа нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэх;</p>	<p>2018 оны жилийн эцсийн байдлаар хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил гаргасан 183 алба хаагчид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж, 495 алба хаагчид Хорих анги, газар, хэлтэс, салбар нэгжийн даргын тушаалаар, нийт 678 буюу нийт алба хаагчдын 22.8 хувьд нь сахилгын шийтгэл ногдуулсан байна.</p> <p>ШШГЕГ-ын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан алба хаагчдын тоог 2017 оны мөн үетэй харьцуулахад 10.9 хувиар өссөн байна. Сахилгын шийтгэлийн өсөлтийн шалтгаан нь алба хаагчид санхүү, эдийн засгийн байдлаас хамаарч гадаад улс /БНСУ/-д ажиллаж амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилгоор ажлаа хаяж явсан зөрчил 51.2 хувийг эзэлж байна.</p> <p>Хорих анги, салбар нэгжийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан алба хаагчдын тоо 40.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2018 онд “Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын гүйцэтгэл, манлайллыг дээшлүүлэх” зорилт дэвшүүлэн ажиллан байна. Үүний дагуу харьяа анги, байгууллагуудад 2018.02.14-ний өдрийн 2а/543, 2018.02.22-ны өдрийн 2а/595 дугаар албан бичгүүдээр үүрэг чиглэл хүргүүлсэн.</p>
		<p>2.2.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон төрийн алба хаагч хооронд гарсан маргааныг хүлээн авч, шийдвэрлэх;</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааныг 12 удаа зохион байгуулж, 4 иргэний өргөдөл, 31 удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт, томилгооны асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:</p> <p>1. Иргэн С.Баатар, Ц.Чинтуяа нарын гомдлыг 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Салбар зөвлөлийн</p>

			<p>хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хурлын тэмдэглэл болон гарсан шийдвэрийг 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01/01, 01/02 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөл болон 2 иргэнд,</p> <p>2. Иргэн Б.Дэлгэрмөрөн, Ц.Дэлгэрсайхан нарын гомдлыг 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэн 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/03 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөл болон 2 иргэнд баталгаат шуудангаар тус тус хүргүүлсэн.</p> <p>Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтан нэг бүрээр хэлэлцүүлэн, холбогдох албан тушаалтанд томилж хэвшсэн бөгөөд 2018 онд Төрийн албаны салбар зөвлөлийн 10 хуралдаанаар 31 удирдах албан тушаалтанг нэр дэвшүүлж, 13 удирдах албан тушаалтанг томиллоо.</p> <p>Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилтийг тооцон ажилласан бөгөөд, хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, албажуулсан.</p>
	<p>2.3. “Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг батлах тухай” Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох</p>	<p>2.3.1. Алба хаагчийг үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшингээр нь сонгон шалгаруулж, удирдах албан тушаалд дэвшүүлэх, хүний нөөцийн сан бүрдүүлэх;</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад анх орох 32, удирдах ажилтны 16, гүйцэтгэх албан тушаалтны 28 алба хаагч болон иргэнийг нөөцөд бүртгэн сан бүрдүүлээд байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудын дутуу орон тоонд тус байгууллагад ажилд орох хүсэлт гаргасан 350 иргэнийг судлан зохих албан тушаалд томилж, тус байгууллагад нэн шаардлагатай эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан 12 иргэнийг дадлагажигч ажилтнаар, иргэд байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдолыг түргэн шуурхай шийдвэрлэх, чигэрэгдэл учруулах үүднээс шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 24 иргэнийг түр орлон гүйцэтгэгчээр, тухайн албан тушаалын болзол шалгуурыг хангасан 171 алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилсон байна.</p>

		2.3.2. Төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс авах мэргэшлийн шалгалтыг Хууль сахиулахын их сургуультай хамтран зохион байгуулах;	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог нөхөх, ахлагч бүрэлдэхүүний нөөц бүрдүүлэх зорилгоор харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтыг 2018 онд 3 удаа зохион байгуулж байна. 1 дүгээр ээлжийн сургалтнаас 90, 2 дугаар ээлжийн сургалтнаас 75 иргэн тэнцэж сургалтад хамрагдаад байна.
		2.3.3. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх, нөхөн хангалтыг хийх;	ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн Харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтыг төгссөн 87 сонсогчийг 2018 оны 06, 11 дүгээр саруудад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ажлыг зохион байгуулж, 165 сонсогчийг албан тушаал томилсон байна.
Гурав. Төрийн захиргааны хөгжлийн бодлого, удирдлага, мэдээллийн тогтолцоо			
3	3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээний төрийн албан хаагчтай холбоотой мэдээ, тайлан, судалгааг Төрийн албаны зөвлөлөөс баталсан загвар, графикийн дагуу гаргаж, хүргүүлэх	3.1.1. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг гаргах талаар харьяа нэгжийн хүний нөөцийн ажилтнуудад арга зүйн зөвлөгөө өгөх, тайланг авч нэгтгэх;	Хүний нөөцийн програмыг шинэчлэн харьяа байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2018.06.22-ны өдөр видео сургалтын зохион байгуулсан.
		3.1.2. Салбар зөвлөлийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэх	Төрийн албаны салбар зөвлөлийн 2017 онд хийсэн ажлын тайлан, өргөдөл гомдол, маргааны мэдээг гаргаж 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор багтааж, Төрийн албаны салбар зөвлөлийн 2018 оны хагас жилийн тайлан, өргөдөл гомдол, маргааны мэдээг гаргаж 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 01/2605 дугаар албан бичгээр тус тус Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.
		3.1.3. Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хүргүүлэх;	1. Иргэн С.Баатар, Ц.Чинтуяа нарын гомдлыг 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хурлын тэмдэглэл болон гарсан шийдвэрийг 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01/01, 01/02 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөл болон 2 иргэнд, 2. Иргэн Б.Дэлгэрмөрөн, Ц.Дэлгэрсайхан нарын гомдлыг 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэн 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/03 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөл болон 2 иргэнд баталгаат шуудангаар тус тус хүргүүлсэн.
	3.2. Төрийн албаны зөвлөлийн “Цахим хуудас”-аар Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэн	3.2.1. Сул орон тооны захиалгад тулгуурлан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх тухай зарлалыг цахим хуудаст байршуулах, хэвлэл мэдээллийн	Сул орон тооны судалгааг 42 удаа гаргаж удирдах албан тушаалтнуудад танилцуулж байна. Эмч, эмнэлгийн ажилтны сул орон тооны сонгон шалгаруулалтын 2018 оны 02 дугаар сарын 08, 03 дугаар

	сурталчлах, холбогдох мэдээллийг түүнд байршуулах ажлыг зохион байгуулах	хэрэгслээр сурталчилж, нээлттэй ил тод байдлыг хангах;	сарын 20-ны өдрүүдэд олон нийтийн хэвлэл болон ШШГЕГ-ын вэб сайтад байршуулсан.
Дөрөв . Төрийн албаны шинэтгэлийн бодлого, хуулийн хэрэгжилтийн мониторинг - үнэлгээ, хяналт шалгалт			
4	4.1. Төрийн албаны шинэчлэлийн бодлого стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж гаргаж холбогдох нэгж, этгээдэд хүргүүлэх	4.1.1 Хяналт шинжилгээ хийх чиглэл, төлөвлөгөөг гарган батлуулж, зохих журмын дагуу хийх, санал зөвлөмж боловсруулан, харьяа нэгжүүдэд хүргүүлэх;	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг тус тус үндэслэж байна.</p> <p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, Байгууллагын ил тод байдлын үнэлгээг гарган 2018 оны 02 дүгээр сарын 01-ний өдрийн ба/363 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2018 оны үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх хөндлөнгийн байгууллагаар “Ажиглалт” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага сонгогдож 2018 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан ба хэрэгжилтийг 94.3 хувиар үнэлсэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдэд хүргэдэг үйлчилгээний талаар хөндлөнгийн буюу “Хэрэглэгчийн үнэлгээ”-г хийлгэх ажлын хүрээнд “Жи Би Эм Сошиал Ресерч Консалтинг” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, 401, 429 дүгээр хаалттай хорих анги, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж, 93.9 хувь буюу 4.7 оноотой дүгнэгдсэн.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2018.02.01-ний өдрийн ба/363 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.</p>

			<p>АТГ-ын даргын 2017.12.28-ны өдрийн А/185 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага дахь Авлигын эрсдлийн үнэлгээний аргачлалын дагуу “Монгол гайхамшиг” ТББ-аас ШШГЕГ-ын эрсдлийн үнэлгээг хийж, Эрсдлийн түвшинг “БАГА” гэж тогтоосон. 2016, 2017 онуудад авлигын эрсдлийн үнэлгээг хийлгэхэд эрсдлийн түвшин “дунд” гэж тогтоосон бол энэ онд “бага” гэж тогтоосон нь өмнөх онуудаас буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, 403 дугаар нээлттэй хорих анги, 441 дүгээр нээлттэй хорих анги, Нийслэлийн Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тасаг, Архангай, Баянхонгор аймаг дахь ШШГГ-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээг тус тус хийж, дүнг нэгтгэн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай үүргийг 2018.05.10-ны өдрийн 01/1841, 2018.06.15-ны өдрийн 01/2388, 2018.07.03-ны өдрийн 6а/4562, 2018.09.12-ны өдрийн 01/3544, 2018.10.09-ний өдрийн 01/3985 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.</p> <p>2017.07.20-ны өдрийн 2а/2366 дугаар “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжид заагдсан арга хэмжээнд 427 дугаар хаалттай хорих ангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт хийхэд 92 хувь буюу 4 оноотой, 2017.11.03-ны өдрийн 4-в/3457 дугаар “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжид заагдсан арга хэмжээнд Баривчлах төвийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт хийхэд 69.3 хувь буюу 3.4 оноотой тус тус дүгнэгдсэн.</p>
	<p>4.2. Ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлөөс баталсан тусгай шаардлагад нийцүүлэн батлах</p>	<p>4.2.1. Шинээр батлагдсан бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн болон шинээр боловсруулж батлуулах;</p> <p>4.2.2 Төрийн албаны салбар зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу нийт албан</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/293 дугаар тушаалын дагуу ШШГЕГ-ын даргын 2018 оны 01 дүгээр 16-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар ШШГЕГ-ын бүтэц, орон тоо, 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/52 дугаар тушаалаар ШШГЕГ-ын алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинээр болон шинэчлэн тус тус баталлаа.</p> <p>“Төрийн алба хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх журмыг”-ыг мөрдөн ажиллаж 2018 онд удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр болон алба хаагчийн өргөдөл, шилжсэн, халагдсан, чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан,</p>

		хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийх;	шилжүүлэн томилсон, сахилгын арга хэмжээ авсан нийт 35359 материалыг холбогдох алба хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийсэн.
Тав. Дотоод зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэх			
5	5.1. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт, хуралдааны шийдвэрийг албажуулсан байдал	5.1.1. Салбар зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг албажуулж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;	Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилтийг тооцон ажилласан бөгөөд, хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, албажуулсан.

ШШГЕГ-ЫН ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

